



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

# БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#4

2022 он

VII сар

Сар тутмын хэвлэл

 <http://www.mnier.mn>

## БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Л.ЭНХ-АМГАЛАНГИЙН МЭНДЧИЛГЭЭ



Хувьсаж буй боловсрол хэлэлцүүлэгт оролцож байгаа Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Уур амьсгалын өөрчлөлт, цар тахал, гео политекийн асуудал нь дэлхий нийтэд боловсролын хөгжлийн шинэ дүр төрхийг тодорхойлох шинэ үеийн хүүхэд залуучууд, иргэдийн боловсролын хэрэгцээг хангах уян хатан, технологид суурилсан, оршихуй нөхцөлдөө дасан зохицож өөрийгөө бүтээн амьдрах нээлттэй, хүмүүнлэг боломжийг бүрдүүлэх зорилтыг гарган тавьж байна.

Хурдтайгаар өөрчлөн шинэчлэгдэж буй цаг үед амьдарч байгаа бидэнд дэлхийн улсуудын хөгж-

-лийн чиг хандлагыг мэдэрч, хүүхэд бүрэн хөгжих эрхийг хангах оновчтой шийдлийг төр, хувийн хэвшлийн түншлэл, нийгмийн зөвшилцөлд тулгуурлан гаргах хариуцлага ноогдож байна. Transforming education буюу “Хувьсаж буй боловсрол”-ын энэхүү үндэсний хэлэлцүүлгээр хөгжлийн дурдсан нөхцөлтэй уялдуулан хувь нэмрээ оруулахаар хүрэлцэн ирсэнд Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Амьдрал, ажил хөдөлмөр, тогтвортой хөгжлийн төлөөх суралцах чадвар, багш, багшийн мэргэжил, тэгш хүртээмжтэй аюулгүй сургууль, боловсролын санхүүжилт, дижитал суралцахуй ба хувирган өөрчлөлт гэсэн чиглэлээр бид үндэсний зорилго, зорилтоо эргэн нягтлан хүн бүр өөрийн оролцоогоо илэрхийлэх гэж байна. Хувьсаж өөрчлөгдөж буй нийгэмд нийгмийн болон байгалийн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх нь бидний үндсэн зорилго билээ.

Чанартай багш, боловс-

-ролын нээлттэй нөөц, хүртээмжтэй дэд бүтэц нь дижитал боловсролыг хөгжүүлэх чиглэл боллоо. Манай улсын хувьд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чанарыг сайжруулах зорилгын хүрээнд 21-р зуунд суралцагчдын чадамжийн загварыг боловсруулсан. Бүх шатны боловсролоор суралцагсад эзэмшиж буй чадварууд тэдгээрийн залгамж холбоог тогтоосон, насан туршийн сурацахуйн тогтолцоог иргэн бүрт хүртээмжтэй байх бодлогын шийдлийг гаргасан, гүйцэтгэлд суурилсан үнэлгээний тогтолцоог бүрдүүлж байгаа орон зай, цаг хугацаанаас үл хамаарсан сургалтын нөхцлийг бүрдүүлж байгаа зэрэг болно. Хүн бүрийн сайн сайхан амьдрахад нь тулгуур болох багшийн дижитал ур чадвар, суралцагч бүрийн хэл соёлын онцлог хэрэгцээг тусгасан сургалтын хөтөлбөр, тэгш хүртээмжтэй санхүүгийн нөөц, цахим сургалтын орчин хэрэглэгдэхүүн, материаллаг болон сэтгэл зүйн орчин, багшлах болон суралцах арга барил, эцэг

эх, хүүхдүүд, багш, сургуулийн ажилтны хамтын ажиллагаанд суурилсан шийдэл гаргах нөхцлийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар бүх шатны боловсролын байгууллагад 50 гаруй мянган багш, 1 сая 100 мянган хүүхэд залуучууд суралцаж төрийн өмчийн ерөнхий боловсролын 672 сургууль шилэн кабельд холбогдож, 88 их, дээд сургууль өндөр хурдны сүлжээнд тус тус холбогдсон бөгөөд боловсролын салбарт дижитал бодлого хэрэгжилт дэд бүтцийг хариуцан ажиллах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж эхлээд байна.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА МОНГОЛ УЛС

UNITED NATIONS TRANSFORMING EDUCATION SUMMIT 2022

“ХУВЬСАЖ БУЙ БОЛОВСРОЛ” ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

**ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА**

САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ I 2022.06.16

САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ II 2022.06.22

САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ III 2022.06.27

САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ IV 2022.06.29

**НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

2022.07.04  
УЛААНБААТАР ХОТ

## “ХУВЬСАЖ БУЙ БОЛОВСРОЛ” ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол Улс нь ТХЗ-ыг анхлан хэрэгжүүлэгч улс орнуудын нэг бөгөөд ТХЗ-ууд, түүний дотор ТХБ-ыг үзэл баримтлал, агуулгын хувьд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогодоо тусган хэрэгжүүлж байна. Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогод сургалтын үйл ажиллагааг уян хатан байдлаар зохион байгуулах нь насан туршийн боловсролыг бодит амьдрал дээр хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл болохыг заасан байна.

Монгол Улсын Засгийн газраас 2019 онд НҮБ-д өргөн мэдүүлсэн ТХЗ-ын хэрэгжилтийн талаарх үндэсний сайн дурын илтгэлд ТХЗ-4-ийн зорилтууд

болон боловсролын салбарыг хөгжүүлэх үндэсний тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд гарсан томоохон ахиц дэвшлийн талаар онцгойлон дурдсан. БШУЯ-наас 2022 онд гаргасан ТХЗ-4-ийг хэрэгжүүлэх явцын талаарх дунд хугацааны тайланд Монгол Улсад тэгш, хүртээмжтэй, чанартай насан туршийн боловсрол олгох чиглэлд гарсан гол ололт амжилтыг илтгэжээ. Эдгээр нь НҮБ-аас дэвшүүлэн тавьсан 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, тухайлбал ТХЗ-4, Монгол Улсад хэрэгжүүлэх НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ баримт бичиг (НҮБТХХАХ)-ийн үзэл санаатай нийцэж байна.

## ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Сурлагын хоцрогдлыг арилгах, ТХЗ-4-ийн хэрэгжилтийг ахиц дэвшлийн замд нь эргэж оруулах, ирээдүйн боловсролыг дахин төлөвлөхөд шаардлагатай бодлого, төлөвлөлт, төсвийн өөрчлөлт, арга хэмжээний эрэл хайгуулд сонирхогч талуудын оролцоог дэмжих, одоогоос 2030 он хүртэлх хугацаанд Монгол Улсын боловсролыг өөрчлөхөд чиглэсэн үндэсний хэмжээний нэгдсэн алс хэтийн зорилго, үүрэг амлалтыг тодорхойлох, улс, орон нутгийн энэ чиглэлийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад оршино.



ТХЗ-4-ийн зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд шаардагдах өсөлтөөс илүүтэй, боловсролын салбарын санхүүжилт буурах эрсдэлтэй байгаа нь боловсролын тогтолцоог илүү тэгш, хүртээмжтэй, ач холбогдолтой, хариу үйлдэл үзүүлэх чадвартай, уян хатан болгохын тулд тогтолцооныхоо талаар дахин эргэцүүлж тунгаах, шинэлэг болгох, өөрчлөх зайлшгүй шаардлагатайг мөн илтгэн харуулж байна.

## ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН АГУУЛГЫН ХҮРЭЭ



БШУЯ-наас баримталж буй “боловсролын шинэчлэлийн бодлого” болон НҮБ-ын Боловсролын ирээдүйн тухай Олон улсын комиссын “Бидний ирээдүйг хамтдаа дахин төсөөлөх нь: боловсролын нийгмийн шинэ гэрээ” илтгэлд тулгуурлан дараах сэдэвчилсэн чиглэлийн дагуу арга хэмжээг зохион байгуулсан.

НҮБ болон Монгол Улсын Засгийн газар одоогоос эхлээд 2030 он хүртэлх хугацаанд боловсролыг хувирган өөрчлөх шинэ буюу шинэчилсэн үндэсний түвшний алс хэтийн зорилтыг тодорхойлоход тус дөхөм үзүүлэх зорилгоор оролцоог хангасан үндэсний хэмжээний хэлэлцүүлэг зохион байгуулахыг зорьсон бөгөөд үндэсний хэлэлцүүлгийг тодорхой үе шаттайгаар, цахим сүлжээний онлайн платформ болон танхимыг хослуулан зохион байгууллаа.

**ОРОН НУТГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

- Салбар салбарын төлөөлөл



**Онлайн хэлбэр**

- Төлөөлөл бүрээр хэлэлцүүлгийн виртуал өрөө үүснэ.
- Өрөө тус бүрд 3-с доошгүй хүнтэй баг ажиллана.
- IT баг



**Хэлэлцүүлгийн агуулгын хүрээ**

- Дижитал суралцахуй ба хувирган өөрчлөлт
- Хүртээмжтэй, тэгш, аюулгүй, эрүүл сургууль
- Амьдрал, ажил хөдөлмөр, тогтвортой хөгжлийн төлөөх суралцах чадвар
- Багш, багшийн мэргэжил
- Боловсролын санхүүжилт

**ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

Орон нутгийн хэлэлцүүлгийн үр дүн

**Танхим болон Онлайн хэлбэр**

- Ажлын алба
- IT баг
- Ажлын хэсэг

**ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**БЭЛТГЭЛ АЖИЛ**

2022.V.15 - VI.20

<b>I</b> үе шат	Ажлын хэсэг байгуулах	Удирдамж боловсруулах	Хэлэлцүүлгийн мэдээлэл, чиглүүлэх асуулт боловсруулах	Зохион байгуулагчдад зориулсан зааварчилга боловсруулах	Чиглүүлэгчдийг бэлтгэх
--------------------	-----------------------	-----------------------	---	---	------------------------

**САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

2022.VI.16 - VII.01

<b>II</b> үе шат	Хэлэлцүүлэг VI.16 Багшийн хөгжлийн ордон	Хэлэлцүүлэг VI.22 ШУТИС-ийн Нээлттэй боловсролын төв	Хэлэлцүүлэг VI.29 Булган, Хялганат ТХБ II төсөл	Хэлэлцүүлэг VI.24 “Туушин” зочид буудал	Хэлэлцүүлэг VII.01 “Янзага” хүүхдийн зуслан
---------------------	---	---	--	--	--

**НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

2022.VII.05

<b>III</b> үе шат	Нэгдсэн хэлэлцүүлгийн бэлтгэл хангах	Танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах	Нэгдсэн хэлэлцүүлгийг зохион байгуулах	Хэлэлцүүлгийн нэгдсэн дүгнэлт	Хэлэлцүүлгийн тайлан бэлтгэх
----------------------	--------------------------------------	--	--	-------------------------------	------------------------------

Үндэсний хэлэлцүүлгийг зохион байгуулахад БШУЯ, түүний харьяа БСҮХ манлайлан ажилласан бөгөөд НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар, НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (БСШУБ)-ын дэмжлэг чухал ач холбогдолтой байлаа.

**САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЙЛ ЯВЦ, ОРОЛЦОГЧДЫН САНАЛААС**

Дэлхий даяар технологийн компанийн хамааралд орсон. Дижитал шилжилт хийхийн тулд боловсролын салбар ихэнх төсвөө технологийн компанид зарцуулж маш их эрсдэлд орж байна. Тэдгээр компанийн мэдэлд ороход хүрээд байна. Тиймээс маш болгоомжтой, ул суурьтай хандах нь чухал. Хувийн IT компанитай БШУЯ-ны хийж байгаа гэрээн дээр иргэний нийгмийн байгууллагууд хүүхдийн эрх, нууцлалын баталгаа, цахим эрсдэл зэрэг талаас үнэлгээ хийж оролцох бүрэн боломжтой. Бидний хүч бололцоог ашиглаасай гэж хүсэж байна.

**Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл**



### Олон улсын байгууллага болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл



Холимог сургалтын арга нь давуу талтай. Онолын мэдлэгээ авчхаад практик тал нь 70 хувь байвал багшид ч хэрэгтэй. Сурагчидтайгаа илүү тулж ажиллана. Ингэвэл ажиллахад хөнгөн болох байх. Түвшнээс хамаараад өөр байвал зүгээр. Хувилбартай байх.

Үе тэнгийн дээрэлхэлтийг үгүй хиймээр байна. Цахим орчинд, бас хөвгүүд бие биенээ их дээрэлхдэг, ядуу айлын хүүхдийг илүү их дээрэлхдэг. Хэл яриа, бие эрхтний онцлогоор ялгаварладаг, дээрэлхдэг.



... Боловсролыг бүх нийтийн зорилго болгох, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэггүй төр, хувийн хэвшлийн байгууллагууд ч өөрийн үйл ажиллагаандаа боловсролын зорилгод тусгасан чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх тогтолцоо, соёлыг бүрдүүлэх, түүнийг урт хугацаандаа тасралтгүй, тууштай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулъя.

### Сурагчдын төлөөлөл



... Бусдыг ойлгох чадвар дутмаг байна. Бие биенээ гомдоох, цаашлаад хүүхдүүд сэтгэл гутралд орох явдал их байна. Нэгнийгээ сэтгэл зүйн хүнд байдалд оруулдаг ингэснээр хүүхэд хөгжих, суралцах үйл ажилагаанд сөргөөр нөлөөлдөг.

... Байгал орчны яам, боловсролын яамтай хамтраад хүүхдүүдийн ногоон ур чадварыг сайжруулах чиглэлээр ажиллаасай, сургалтын агуулгад оруулаасай.

### Бизнес эрхлэгчдийн төлөөлөл

Нэгдсэн платформ дээр зөвхөн төрийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа сургалтын материал биш бизнесийн байгууллагын тодорхой шалгуур хангасан сургалтын хөтөлбөр, материалыг оруулж хүүхдүүдэд нэгдсэн байдлаар хүрэх боломжийг нээж өгч болох юм. Энэ нь төр, бизнесийн байгууллага хоорондын уялдаа холбоог гаргах төдийгүй бизнесийн байгууллагуудын маркетингийн зардлыг хэмнэх томоохон ажил болно.



### Хэвлэл мэдээллийн төлөөлөл

Хэрэглэгчид суралцагчдын саналыг хүлээн авч, шийдвэрлүүлэхэд анхаардаг, шийдвэрлүүлэх тал дээр ажилладаг, тогтвортой үйл ажиллагаа бүхий бүлгүүдийг, нэгжүүдийг дүүргийн, нийслэлийн, аймгийн, сумын хэмжээнд байгуулах. Энэ нь хүүхдүүд, залуучууд бидний дуу хоолойг сонсох, санал санаачилгыг дэмжих нэг суваг болно гэж үзэж байна.

### Залуусын төлөөлөл

... Оюутан, залуучуудыг цалинтай дадлага хийж, ур чадвараа хөгжүүлэх боломжоор хангах хэрэгтэй байна. Цалин хөлс нь мөнгөн бус урамшуулал байж болно. Залуучууд практик нөхцөлд ур чадвараа хөгжүүлэх боломж олгосны хариуд бүтээгдэхүүнийг нь цахим болон энтертайнмент хэлбэрээр сурталчилж өгдөг байж болно...

.... Ажил олгогчид ажилд авахдаа ажлын туршлага заах бус ур чадвараар нь тохирсон ажил олгох боломжийг нээлттэй байлгах хэрэгтэй...

... Сургууль төгссөн хүүхдийг 1 жил дадлагажуулж байж сая нэг ажилтан болгож байна. Нэг ажилтныг бэлдэхэд ойролцоогоор 15 сая төгрөг зарцуулж байна. Хувийн байгууллага бүр 2 сая төгрөг гаргаад сан үүсгээд, төгсөгчдийг мэргэшсэн, ур чадвартай ажилтан болгоход зарцуулъя.



### Залуучууд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл


Багш, эцэг эх, асран хамгаалагчид, суралцагчид хэн нь ч эгэх хариуцлагатай байх чадварыг эзэмшвэл сурлагын хоцрогдлыг арилгах, сургуулийг тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй болгоход чиглэсэн бодлого амьдрал дээр хэрэгжих боломж бүрдэнэ гэж үзэж байна.

“Хувьсаж буй боловсрол” дээд хэмжээний уулзалтын өмнөтгөл болгож үндэсний хэмжээнд 5 салбар, төгсгөл болгож нэгдсэн нийт 6 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд нийт 600 гаруй тооны хүн оролцсон байна. Оролцогчдын тоог салбар хэлэлцүүлэг бүрээр дараах хүснэгтэд үзүүлэв.


Салбар хэлэлцүүлэг 1	Салбар хэлэлцүүлэг 2	Салбар хэлэлцүүлэг 3	Салбар хэлэлцүүлэг 4	Салбар хэлэлцүүлэг 5	Нэгдсэн хэлэлцүүлэг
Эрдэмтэн судлаачид	Залуучуудын, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл	Өсвөр үеийн төлөөлөл	ТХ-ийн төлөөх сургуулийн төлөөлөл: багш, удирдлага, сурагч, үндэсний болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл	10-15 насны хүүхдийн төлөөлөл	Салбар хэлэлцүүлэгт оролцогчдын төлөөлөл
<b>40</b>	<b>215</b>	<b>42</b>	<b>155</b>	<b>40</b>	<b>139</b>

Салбар хэлэлцүүлэгт оролцогчдын 74 хувь нь танхим, 26 хувь нь онлайн хэлбэрээр оролцсон байна.

Насныхаа талаар мэдээлэл өгсөн оролцогчдын ихэнх хувийг 18-29 насныхан эзэлж байх бөгөөд мөн хүйсээ мэдээлсэн оролцогчдын 64 хувь нь эмэгтэй, 36 хувь нь эрэгтэй байна.



Хэлэлцүүлэгт оролцогчдыг салбарын төлөөлөлөөр авч үзвэл олонх нь багш, боловсролын ажилтан, иргэний нийгэм, залуучууд болон өсвөр насныхны төлөөлөл



Тухайн салбар хэлэлцүүлгээр зорилтот бүлэгт хамаарах сэдэвчилсэн чиглэлийн хүрээнд асуудлыг хэлэлцэж, санал санаачилгыг гаргалаа.

**Зорилтот бүлгийн хэлэлцсэн асуудлын чиглэл**

Сэдэвчилсэн чиглэл	Зорилтот бүлэг 1 <b>Залуучуудын төлөөлөл</b>	Зорилтот бүлэг 2 <b>Сургуулийн удирдлага, багш, сурагч</b>	Зорилтот бүлэг 3 <b>Иргэний нийгмийн байгуулал</b>	Зорилтот бүлэг 4 <b>Аж ахуйн нэгж байгууллага</b>	Зорилтот бүлэг 5 <b>Хэвлэл мэдээлэл</b>
Дижитал суралцахуй ба хувирган өөрчлөлт	✓	✓	✓	✓	✓
Тэгш, хүртээмжтэй, аюулгүй, эрүүл сургууль	✓	✓	✓		✓
Амьдрал, ажил хөдөлмөр, ТХ -ийн төлөөх суралцахуй ба ур чадварууд	✓	✓		✓	✓
Багш, багшлахуй болон багшийн мэргэжил	✓	✓	✓		
Боловсролын санхүүжилт		✓	✓	✓	

Сэдэвчилсэн чиглэл тус бүрт ирсэн саналыг тоогоор илэрхийлбэл дараах байдалтай байна.

- Дижитал суралцахуй - 212
- Тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй сургууль- 223
- Багш, багшлахуй, багшийн мэргэжил -304
- Ажил, амьдрал, тогтвортой хөгжлийн төлөөх суралцахуй ба ур чадвар- 136
- Боловсролын санхүүжилт- 157

Хэлэлцүүлгүүдийн үр дүнг сэдэвчилсэн 5 чиглэл бүрээр нэгтгэн харахад бүх талын оролцоо, хамтын ажиллагаа, түншлэл дор сурлагын хоцрогдлыг арилгах, боловсролыг хувирган өөрчлөхийг эрмэлзэж, тодорхой санал, санаачлагыг дэвшүүлж байна.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс хэлэлцүүлгүүдийн үр дүнг нэгтгэн хүүхэд бүрд тэгш, хүртээмжтэй боловсролын үйлчилгээ үзүүлэх болон боловсрол, боловсролын тогтолцоог хувирган өөрчлөх гэсэн хоёр агуулгын хүрээнд Монгол Улсын үүрэг амлалтын төслийг боловсруулсан бөгөөд үүнд нийт 19 санаачилга багтсан байна. Тухайлбал,

**КОВИД-19 цар тахлын дараа сургуулийг бүрэн нээсэн үр дүнгээ бататгаж, хүүхэд бүрийг боловсролд хамруулах чиглэлээр:**

**1** Оношилгоо, үнэлгээний үр дүн, суралцагч бүрийн онцлог, ялгаатай байдалд суурилан сургалтын агуулга, чадварын хоцрогдлыг нөхөх, холбогдох нөөцийг тасралтгүй хөгжүүлэх;

**2** Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулж, тэдний онцлог, сурах хэв маягт нийцүүлэн суралцах үйлийг дэмжих, хүртээмжтэй орчин бүрдүүлэхэд бүх талын оролцоо, түншлэлийг идэвхжүүлэн хувь хүний онцлогт нийцсэн боловсролын үйлчилгээ үзүүлэх;

**3** Боловсролын системийг сэргээх, боловсролын зорилгуудад хүрэх ажлуудын эрэмбэ дараалал тогтоож, инновацыг нэвтрүүлж, үсрэлт хийж чадваас боловсролын системийг эмхлэн цэгцэлж, өөрчлөн хувиргаж чадах болно гэдэг итгэл үнэмшил төрж байна.

КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй сурлагын хоцрогдлыг нөхөх, хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд ажиллаж



амьдрахад чухал ач холбогдолтой метатанин мэдэхүй (thinking about thinking), суралцахууд суралцахуй (learning to learn), сэтгэл хөдлөлөө удирдах (emotional regulation), аливаа зүйлд зорилго тавьж (goal orientation), тууштай байх (perseverance), бусдыг ойлгох (empathy) зэрэг чадваруудыг сургалтын үйл ажиллагаанд нэмэж тусган хөгжүүлэх шаардлагатай байна.

### Боловсрол, боловсролын тогтолцоог хувиргах чиглэлээр:

#### Ур чадвартай, нийгмийн баталгаагаар хангагдсан багш

**4** Боловсролыг өөрчлөн цэгцлэх асуудал багшийн мэргэжлийг өөрчлөн шинэчлэхгүйгээр хэрэгжихгүй. Багш бол хичээл заахаас бие даан суралцах үйл ажиллагааг дэмждэг, чиглүүлдэг болох шаардлагатай.

**5** Багшийн ажил үүрэг, хөдөлмөр эрхлэх орчны өөрчлөлтөд нийцүүлэн багшийн стандартыг шинэчлэх, багш бэлтгэх сургуульд чадварлаг сурагчдыг элсүүлэх тусгайлсан бодлого баримтлан хэрэгжүүлэх;

**6** Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих тогтолцоог

хөгжүүлэхэд талуудын идэвхтэй хамтын ажиллагаа, оролцоог дэмжих, багшийн ажлын байран дээрээ хөгжих боломжоор хангах (дигитал ур чадвар, контент бүтээх ур чадварт суралцах Мэргэжилтнүүд сургууль дээр нь багштай хамтарч ажилладаг байх тогтолцоо);

**7** Багшийн нэр хүнд, үнэлэмж, амьдралын чанарыг сайжруулахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, багшийг нийгмийн тэргүүлэх мэргэжилтэн гэж үзэж тусгайлан дэмжлэг үзүүлэх санаачилга өрнүүлэх;

#### Ажил, амьдрал, тогтвортой хөгжлийн төлөөх суралцахуй ба ур чадвар

**8** Суралцагчдад мэдлэгээ хэрэглэх, амьдралд хэрэгцээтэй мэдлэг, ур чадвар, өөрчлөгдөж байгаа ажлын байрны ур чадвар, тогтвортой хөгжлийн ур чадварыг олгоход онцгой анхаарч ажиллана.

**9** Хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд ажиллаж, амьдрахад шаардагдах мета-

танин мэдэхүй, суралцахууд суралцахуй, сэтгэл хөдлөлөө удирдах, аливаа зүйлд зорилго тавьж, тууштай байх, бусдыг ойлгох зэрэг чадварыг хөгжүүлэх, насан туршдаа суралцахуйг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамтын ажиллагаа, түншлэлээр дэмжиж хөрөнгө оруулалт хийх;

**10** Техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, их, дээд сургууль, коллежид элсэгч болон төгсөгчдийн ур чадварыг үнэлэхэд ажил олгогчдын оролцоог хангаж, ур чадварыг хөгжүүлэх, баталгаажуулахад хамтран ажиллах;

**11** Үндэсний хэмжээнд сургуулийн менежментийн чадварыг дээшлүүлэх (сургууль, сургалтын байгууллагын бүхлээр ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх);

**12** Сургуулийн бие даасан байдлыг дэмжиж, шийдвэр гаргахад суралцагч, эцэг эх, олон нийтийн оролцоог ханган саналыг тусгах, түншлэл, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, нөөцийг үр ашигтай ашиглах замаар тэгш хүртээмжтэй, эрүүл, аюулгүй

### Дижитал суралцахуй

**15** Сургалтын нээлтэй нөөцийг хөгжүүлэх, нэгдсэн сан бүрдүүлэх, боловсролын платформыг хөгжүүлэн нэвтрүүлэх, тэдгээрийг ашиглах нээлттэй, тэгш боломжийг (үнэ төлбөргүй) хангах;

**16** Хүртээмжтэй, дижитал хуваагдлаас сэргийлсэн, уян хатан, аюулгүй байдлыг хангахуйц тоног төхөөрөмж, өндөр хурдтай найдвартай сүлжээ, дэд бүтцийг бий болгож, хөгжүүлэх;

### Боловсролын санхүүжилт

**17** Боловсролын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд олон талын оролцоог хангах, санхүүжилтэд инновацыг нэвтрүүлэх, хяналт бий болгох; Аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагаас боловсролд хөрөнгө оруулахтай холбоотой төрөөс үзүүлэх хөшүүрэг, дэмжлэгийг нэмэгдүүлэх, хамтран ажиллах;

### Тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй сургууль

суралцахуйн орчныг эрс сайжруулах;

**13** Материаллаг болон сэтгэл зүйн орчны хувьд суралцагчдад суралцах, хөгжих таатай, ээлтэй орчныг цогцоор бүрдүүлэх, ялангуяа суралцагчдын нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үйлчилгээнд анхаарал хандуулах, эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх;

**14** Суралцагч бүрд ямар ч нөхцөл байдалд насан туршдаа боловсрол эзэмших боломжийг олгохуйц байх нөхцөлийг бий болгох хэрэгтэй.



**18** Боловсролын чанарыг сайжруулах, багшийн хөгжилд зориулсан олон талын санхүүжилтийн санал санаачилгыг нэмэгдүүлэх;

**19** Боловсролын төсөв, төлөвлөгөөг ялгаварлан гадуурхалгүй, тэгш боломжоор хангасан, зорилтот стратегиар боловсруулж, хэрэгжүүлэх;

2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр нэгдсэн хэлэлцүүлгийг төрийн захиргааны төв байгууллага (яам, элчин), олон улсын байгууллага, агентлаг, мэргэжлийн байгууллага, их, дээд сургууль, төрийн бус байгууллага, бизнес, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, төсөл хөтөлбөр, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан бөгөөд нийт 6 дэд багаар ажиллаж, өөрсдийн санал, бодлыг илэрхийлсэн байна.

Нэгдсэн хэлэлцүүлгээр оролцогчид Монгол Улсын үүрэг амлалтын төсөлд тусгасан дээрх 19 санаачилгыг ач холбогдол (чухал)-оор нь дараах байдлаар эрэмбэлсэн байна.

0-5 хүртэлх	6-10 хүртэлх	11-20 хүртэлх	21-30 хүртэлх
1	3, 4, 10, 18	7, 8, 11, 13, 14, 16, 19	2, 5, 6, 9, 12, 15, 17

Тодруулбал, нийт оролцогчдын 30 хүртэлх хувь нь 2, 5, 6, 9, 12, 15, 17 дугаартай санаачилгыг чухал гэж үзсэн байна.

Тэр дундаа гурван оролцогч тутмын нэг нь 5, 6, 9 дугаартай буюу багшийн стандартыг шинэчлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих болон багш бэлтгэхэд тусгайлсан бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, суралцагчдын ажиллаж амьдрахад шаардлагатай зөөлөн ур чадварыг хөгжүүлэхэд анхаарч

сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах санаачилгуудыг чухалд тооцжээ. Мөн сургалтад хэрэглэх нээлттэй нөөц, цахим сан бүхий боловсролын үнэ төлбөргүй платформ бий болгох, боловсролд зарцуулж буй санхүүжилтийг нэмэгдүүлэхийн тулд олон талын оролцоог хангах, ялангуяа хувийн бизнесийн байгууллагаас боловсролд зарцуулах хөрөнгө оруулалтыг төрөөс дэмжих, хамтран ажиллахыг чухалчилжээ.

Нэгдсэн хэлэлцүүлэгт оролцогчид КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй сурлагын хоцрогдлыг нөхөх, хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд ажиллаж амьдрахад чухал ач холбогдолтой мета-танин мэдэхүй (thinking about thinking), суралцахуйд суралцахуй (learning to learn), сэтгэл хөдлөлөө удирдах (emotional regulation), аливаа зүйлд зорилго тавьж (goal orientation), тууштай байх (perseverance), бусдыг ойлгох (empathy) зэрэг чадварыг сургалтын үйл ажиллагаанд тусган хөгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.



Боловсролыг өөрчлөн цэгцлэх асуудал бол боловсролын зорилгыг өөрчилж, суралцахуй гэж юу болох, яаж сурах тухай асуудал болж байна. Суралцагч нэг бүрд мэдлэг, ур чадвар, амьдралд эрхэмлэж явах зүйл (value)-ийг эзэмшүүлэх чадвартай боловсролын цоо шинэ системийг бий болгох шинэ бодлого, хандлага, арга барил, засаглалын системийг олон улсын нийгэмлэгийн тусламжтай өөрийн орны нөхцөл байдалд хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах ёстой болж байна.



Боловсролыг улс төрөөс ангид байлгах, эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах, тэгш хүртээмжтэй, чанартай боловсролын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур аргачлалыг тусгайлан боловсруулж, боловсролын албан ёсны мэдээллийн санд тэдгээртэй холбоотой өгөгдөл мэдээллийг цуглуулж, нотолгоонд суурилсан бодлого төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх түвшинд талуудын оролцоог хангах хэрэгцээ байна.

**Дүгнэлт:**

Монгол Улсын боловсролын ирээдүйн талаар “Хувьсаж буй боловсрол” сэдвийн хүрээнд, олон талын төлөөллийн оролцоотой хэлэлцсэн нь 2022 оны есдүгээр сард болох НҮБ-ын Ерөнхий ассамблейн хүрээнд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеришийн ивээл дор зохион байгуулагдах “Хувьсаж буй боловсрол” дээд хэмжээний чуулга уулзалтад Монгол Улсын танилцуулах үүрэг амлалт, санал санаачилгыг боловсруулахад чухал үүрэгтэй байлаа. Монгол Улсын “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2030 зэрэгт тусгасан үндэсний стратеги, зорилго, хэрэгжүүлж буй эрх зүй, бодлогын шинэчлэл болон НҮБ-ын Боловсролын ирээдүйн тухай Олон улсын комиссын “Бидний ирээдүйг хамтдаа дахин төсөөлөх нь: боловсролын нийгмийн зөвшилцөл”-ийн агуулгын хүрээнд хэлэлцүүлгийн оролцогчдын дэвшүүлсэн санал санаачилга нь Монгол улсын үүрэг амлалт, санал санаачилгын үндэс болсон байна.

Хэлэлцүүлгийн оролцогчид “боловсрол бол бүх нийтийн сайн сайхан”-ны үндэс, “боловсрол бүх нийтийн зорилго” болохыг чухалчлан тэмдэглэсэн байна.

Боловсролыг бүх нийтийн зорилго болгох, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэггүй төр, хувийн хэвшлийн байгууллагууд ч өөрийн үйл ажиллагаандаа боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх тогтолцоо, соёлыг бүрдүүлэх, түүнийг урт хугацаандаа тасралтгүй, тууштай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах хүсэл зоригтой байна.

Боловсролыг өөрчлөн цэгцлэх гэдэг бол ганц хоёр том асуудлыг сонгон авч шийдэх тухай биш, боловсролын салбарын хоцрогдлыг арилгах, засах, сайжруулах тухай асуудал гэдгийг талуудын төлөөлөл санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрлөө.

Энэхүү үндэсний хэлэлцүүлгийг **манлайлан зохион байгуулсан** БШУЯ, хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлсэн НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар, НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (БСШУБ) болон хэлэлцүүлэгт оролцсон бүх байгууллага, төлөөлөлд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн талархлыг уламжилж байна.

**ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА ХИЧЭЭЦГЭЭЕ.**